



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ
2022 ОНЫ НЭГДСЭН ТАЙЛАН



Улаанбаатар хот
2022 он

АГУУЛГА

| | |
|---|----|
| НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД..... | 2 |
| 1.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ..... | 2 |
| 1.2. ХӨРВӨХ ЧАДВАР | 3 |
| 1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД | 3 |
| ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ..... | 4 |
| 2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ | 4 |
| 2.1.1. Хувьцааны арилжаа..... | 4 |
| 2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа | 6 |
| 2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа..... | 7 |
| 2.1.4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа..... | 8 |
| 2.1.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас | 8 |
| 2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ | 10 |
| 2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц | 10 |
| 2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА..... | 10 |
| ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД | 11 |
| ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ | 13 |

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хөгжлийн түвшнийг үнэлж, тогтоох хүрээнд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн голлох үзүүлэлтүүд болох дараах индикаторуудыг оруулсан байдаг: зах зээлийн үнэлгээ, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хөрвөх чадвар, хувьцааны индекс.

1.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2022 оны жилийн эцсийн байдлаар 6.89 их наяд төгрөг болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.17 хувиар өссөн бөгөөд уг үзүүлэлт ДНБ-ний 14.35 хувийг эзэлж байна.


График 1. ДНБ-д харьцуулсан хөрөнгийн зах зээлийн үнэлгээ



Тайлбар: 2022 оны ДНБ-нийг сүүлийн 5 жилийн дундаж өсөлтөөр урьдчилан тооцож гаргасан болно.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг бүрдүүлж байгаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 184 компаниас 30 компанийн зах зээлийн үнэлгээ хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээний 93.88 хувийг бүрдүүлж байна.


График 2. Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 30 компани



1.2. ХӨРВӨХ ЧАДВАР

Тайлант хугацаанд хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.42 функтээр буурч, 2.43 хувьд хүрсэн байна. Манай улсын хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар бага байгаа нь хувьцааны хэт төвлөрөлтэй холбоотой юм. Тухайлбал 2022 оны жилийн эцсийн байдлаар ТОП-20 индексэд багтах ХК-уудын хувьцааны төвлөрлийг тооцож үзэхэд хэт төвлөрөлтэй буюу нийт хувьцааны 76.08 хувийг нийт хувьцаа эзэмшигчдийн 0.05 хувь нь эзэмшиж байна.

График 3. Хөрвөх чадвар /хувиар/



1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргадаг. Зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компаниас бүрдэж буй ТОП-20 индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 44,119.22 нэгж, доод үзүүлэлт 32,795.68 нэгж, дундаж үзүүлэлт 36,252.42 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,846.05 нэгжээр буюу 15.42 хувиар буурч, 37,565.55 нэгж болсон байна.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-аас 2018 онд үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хамаарах MSE-A болон MSE-B индексийг тооцон гаргадаг болсон. MSE-A индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 15,779.73 нэгж, доод үзүүлэлт 11,622.85 нэгж, дундаж үзүүлэлт 13,295.00 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,344.83 нэгжээр буюу 8.69 хувиар буурч, 14,137.94 нэгж болсон байна.

Харин MSE-B индексийн дээд үзүүлэлт 12,779.75 нэгж, доод үзүүлэлт 11,397.98 нэгж, дундаж үзүүлэлт 12,012.79 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 464.88 нэгжээр буюу 3.81 хувиар өсөж, 12,667.44 нэгж болсон байна.

Хүснэгт 1. Индексийн үзүүлэлт

| Индекс | 2021 | 2022 | Өөрчлөлт |
|--------|-----------|-----------|----------|
| ТОП 20 | 44,411.60 | 37,565.55 | -15.42% |
| MSE A | 15,482.77 | 14,137.94 | -8.69% |
| MSE B | 12,202.56 | 12,667.44 | 3.81% |

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК


ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ

Тайлант хугацаанд нийт **594.85** тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн байна. Дотоодын хөрөнгийн зах зээлд зөвхөн хувьцаа, компанийн бонд, ЗГҮЦ гэсэн 3 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагддаг байсан бол 2020-2022 онд биржээр арилжаалагддаг хамтын хаалттай ХОС, арилжааны зориулалттай ХБҮЦ, анхны дижитал компанийн бонд /Monpay/, банкны реформын хүрээнд гарсан банкны IPO /Богд банк ХК, Төрийн банк ХК, Голомт банк ХК/ зэрэг шинэ бүтээгдэхүүнүүдийн арилжаа амжилттай арилжаалагдсан.

Мөн тайлант хугацаанд хувьцааны арилжаа түлхүү явагдсан бөгөөд нийт үнэт цаасны арилжааны **57.73** хувийг хувьцаа, **22.54** хувийг компанийн өрийн хэрэгсэл, **17.45** хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, **2.29** хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа тус тус эзэлж байна.

График 4. Үнэт цаасны арилжааны хэмжээ /бүтээгдэхүүний төрлөөр/



Нийт үнэт цаасны арилжааны хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.38 дахин буурсан үзүүлэлттэй байна.


Харин Хөдөө аж ахуйн биржээр тайлант хугацаанд 184 удаагийн цахим арилжаа зохион байгуулгдсан ба нийт 1.1 их наяд төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан байна.

2.1.1. Хувьцааны арилжаа

Тайлант хугацаанд нийт 343.4 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд хувьцааны хоёрдогч зах зээлд нийт 167.6 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

График 5. Хувьцааны арилжаа



Хувьцааны арилжааг “Монголын Хөрөнгийн Бирж” ХК дээр бүртгэлтэй нийт 183 компаниар ангилбал 30 компанийн хувьцааны арилжааны дүн нийт хувьцааны арилжааны 48.4 хувийг бүрдүүлж байна. Үүнд:

Хүснэгт 2. Арилжааны хэмжээ хамгийн өндөр 30 компанийн арилжааны үнийн дүн /тэрбум төгрөгөөр/

| № | Компанийн нэр | Арилжааны үнийн дүн | № | Компанийн нэр | Арилжааны үнийн дүн |
|----|---|---------------------|----|----------------------------|---------------------|
| 1 | “АПУ” ХК | 64.22 | 16 | “Говь” ХК | 2.10 |
| 2 | "Ард санхүүгийн нэгдэл" ХК | 23.12 | 17 | “Улсын Их Дэлгүүр” ХК | 1.94 |
| 3 | “Хөсөг Трейд” ХК | 14.26 | 18 | “Бодь Даатгал” ХК | 1.79 |
| 4 | “Сентрал экспресс Си Ви Эс” ХК | 7.52 | 19 | “Төрийн Банк” ХК | 1.71 |
| 5 | “Голомт Банк” ХК | 6.36 | 20 | “Крипто Үндэстэн” ХК | 1.71 |
| 6 | “Инвескор ББСБ” ХК | 4.43 | 21 | “Баянгол Зочид Буудал” ХК | 1.38 |
| 7 | “Түмэн шувуут” ХК | 3.80 | 22 | “Ард Кредит ББСБ” ХК | 1.26 |
| 8 | “Таван Толгой” ХК | 3.69 | 23 | “Мон Бийф” ХК | 1.16 |
| 9 | “Монгол Шуудан” ХК | 3.56 | 24 | “Богд Банк” ХК | 1.07 |
| 10 | “Мандал Ирээдүйн Өсөлт” | 3.47 | 25 | “Сүү” ХК | 0.70 |
| 11 | “Монос Хүнс” ХК | 3.36 | 26 | “Үндэсний хувьчлалын сан” | 0.69 |
| 12 | “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК | 2.85 | 27 | “Хот Девелопмент” ХК | 0.68 |
| 13 | “Талх Чихэр” ХК | 2.81 | 28 | “Тэнгэрлиг медиа групп” ХК | 0.61 |
| 14 | “Мандал Даатгал” ХК | 2.48 | 29 | “Сэндли ББСБ” ХК | 0.56 |
| 15 | “Ард Даатгал” ХК | 2.42 | 30 | “Монинжбар” ХК | 0.48 |
| | | НИЙТ | | | 166.17 |

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

2.1.1.1. Багцын арилжаа

Тайлант хугацаанд нийт 22 хувьцаат компанийн 84.12 сая ширхэг буюу 70.89 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий багцын арилжаа хийгдсэн нь нийт хувьцааны зах зээлийн арилжааны 20.64 хувийг эзэлж байна.

Хүснэгт 3. Багцын арилжаа хийгдсэн компаниуд

| № | ҮНЭТ ЦААСНЫ НЭР | Арилжсан ширхэг /мян. ширхэг/ | Үнийн дүн /тэр.бум төг/ |
|------------|---|-------------------------------|-------------------------|
| 1 | “Ард санхүүгийн нэгдэл” ХК | 202.03 | 1.27 |
| 2 | “Ард Даатгал” ХК | 749.00 | 0.71 |
| 3 | “АПУ” ХК | 34,111.96 | 49.52 |
| 4 | “Бодь Даатгал” ХК | 6,666.67 | 1.09 |
| 5 | Крипто Үндэстэн ХК | 25.00 | 1.29 |
| 6 | “Сентрал экспресс Си Ви Эс” ХК | 16,493.16 | 3.40 |
| 7 | “Даваанбулаг” ХК | 1,729.70 | 0.39 |
| 8 | “Эрэнцав” ХК | 72.12 | 0.09 |
| 9 | “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК | 315.28 | 0.25 |
| 10 | “Голомт Банк” ХК | 530.59 | 0.68 |
| 11 | “Хөнгөн Бетон” ХК | 58.33 | 0.01 |
| 12 | “Хишиг Уул” ХК | 217.06 | 0.14 |
| 13 | “Хөвсгөл” ХК | 48.69 | 0.00 |
| 14 | “Инвескор ББСБ” ХК | 451.47 | 2.03 |
| 15 | “Женко Тур Бюро” ХК | 4,548.77 | 0.30 |
| 16 | “Монинжбар” ХК | 4,231.92 | 0.46 |
| 17 | “Монгол Шуудан” ХК | 4,832.69 | 3.23 |
| 18 | “Монгол Шевро” ХК | 25.28 | 0.25 |
| 19 | “Хот Девелопмент” ХК | 8,387.77 | 0.50 |
| 20 | “Талх чихэр” ХК | 71.25 | 2.45 |
| 21 | “Тавантолгой” ХК | 379,70 | 2.80 |
| 22 | "Өлзий-Дундговь" ХК | 6.80 | 0.00 |
| ДҮН | | 84,125.23 | 70.89 |


Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа

Тайлант хугацаанд компанийн өрийн хэрэгслийн нийт арилжаа 134.06 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.8 дахин буурсан үзүүлэлт юм.

Компанийн өрийн хэрэгслийн анхдагч зах зээлд нийт 99.72 тэрбум төгрөг, хоёрдогч зах зээлд нийт 34.34 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийгдсэн байна.

График 6. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа



Хороо тайлант хугацаанд 2 компанийн гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэсэн. Үүнд:

- “Ард Кредит ББСБ” ХК нь хаалттай хүрээнд гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 70,000 ширхэг өрийн хэрэгслийг бүртгүүлсэн.
- “Инвескор ББСБ” ХК нь хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 500,000 ширхэг өрийн хэрэгслийг бүртгүүлснээс “Инвескор Бонд 2.0”, “Инвескор Бонд 2.0 – Транч 2”-ийг тус тус гарган нийт 20 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлээд байна.


2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсанаас хойш 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 38 компани хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна.

Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2 компани авсан байна. Үүнд:

- “Мандал ассет менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулсан “Мандал хуримтлал” хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сан нэгж эрхийг анхдагч зах зээлд арилжих ажиллагааг амжилттай зохион байгуулж, 56 хөрөнгө оруулагчдаас 1,002,920,000 ширхэг нэгж эрхийг нэг бүрийг 1 /нэг/ төгрөгөөр олон нийтэд санал болгон арилжаалж, нийт 1,002,920,000 төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.
- “Ард менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулсан “Хөрөнгө оруулагч үндэстэн” хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сан нэгж эрхийн анхдагч зах зээлд арилжих ажиллагааг амжилттай зохион байгуулж, 912 хөрөнгө оруулагчдаас 2,877,102 ширхэг нэгж эрхийг нэг бүрийг 1,000 /нэг мянга/ төгрөгөөр олон нийтэд санал болгон арилжаалж, нийт 2,877,102,100 төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

График 7. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа



Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн анхдагч зах зээлд нийт 3.88 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бол хоёрдогч зах зээлд нийт 9.74 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

2.1.4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

Тайлант хугацаанд Хөдөө аж ахуйн бирж нь 184 удаагийн цахим арилжаа зохион байгуулан нийт 1.1 их наяд төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалсан нь өмнөх оны мөн үеэс 315.84 тэрбум төгрөгөөр буюу 39.75 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд дараах 5 төрлийн бүтээгдэхүүн нийт арилжааны 99.99-ийг бүрдүүлж байна. Үүнд:

Зураг 1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа




Нийт арилжааны үлдсэн хувийг бодын хөөвөр болон мал бэлтгэл бүрдүүлнэ. Тухайлбал тайлант хугацаанд 13.7 сая төгрөгийн бодын хөөвөр, 2 сая төгрөгийн мал бэлтгэлийн бүтээгдэхүүн арилжаалагдсан байна.

2.1.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас


Сүүлийн жилүүдэд банк бус санхүүгийн байгууллагуудын зүгээс хөрөнгийн зах зээлийн уламжлалт бүтээгдэхүүнүүдээс гадна хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар олон нийтээс санхүүжилт татах ажиллагаа идэвхжиж байна. Тухайлбал тайлант онд нийт 6 удаагийн нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зах зээлд амжилттай арилжаалагдаж, олон нийтээс нийт 89.85 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

График 8. Нээлттэй хүрээнд гаргасан ХБҮЦ-ны арилжаа



Тайлант хугацаанд анхдагч зах зээлд хөрөнгийн биржээр 85.0 тэрбум, андеррайтер төвтэй 4.85 тэрбум төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нийтэд санал болгон арилжаалагдсан байна. Хоёрдогч зах зээлд нийт 13.9 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийгдсэн байна.

График 9. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа



Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох зорилгоор 2013 оноос бага хүүтэйгээр орон сууцны зээлийг иргэдэд олгож эхэлсэн. Өнөөгийн байдлаар “МИК ОССК” ХХК-аас 32 ТЗК үүсгэн байгуулсан ба хаалттай хүрээнд нийт 104,660 зээлдэгчийн ипотекийн зээлийг үнэт цаасжуулж 6.2 их наяд төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлснээс 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 67,103 зээлдэгчийн 3.37 их наяд төгрөгийн орон сууцны зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаасны үлдэгдэлтэй байна. Тайлант хугацаанд 17,684 зээлдэгчийн ипотекийн зээлийг багцлан 1,324.44 тэрбум төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгүүлсэн байна.

Хүснэгт 4. Төрийн бодлогын хүрээнд гарсан ХБҮЦ /“МИК ОССК” ХХК /

| Тайлант хугацаанд | Зээлийн багц | Бүртгүүлсэн дүн |
|-------------------|-----------------|-----------------|
| “МИК ОССК” ХХК | 17,684 зээлдэгч | 1,324.44 тэрбум |

Мөн Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжүүлэх дэд арга хэмжээний хүрээнд “Үнэт цаасны санхүүжилтийн корпораци”-аас 4 ТЗК үүсгэн байгуулж, хаалттай хүрээнд уул уурхайн бус экспортын салбарын болон жижиг, дунд үйлдвэрлэгчид олгосон нийт 2,298 зээлийг багцлан 538.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргаад байна. Тайлант хугацаанд 1,037 зээлийг багцлан 329.4 тэрбум төгрөгийн уул уурхайн бус экспорт болон жижиг, дунд үйлдвэрийн зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаасыг бүртгүүлсэн байна.

Хүснэгт 5. Төрийн бодлогын хүрээнд гарсан ХБҮЦ /“ҮЦСК” ХХК /

| Тайлант хугацаанд | Зээлийн багц | Бүртгүүлсэн дүн |
|-------------------|----------------|-----------------|
| “ҮЦСК” ХХК | 1,037 зээлдэгч | 329.4 тэрбум |

Түүнчлэн Коронавируст халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр Монгол Улсын Их Хурлаас 2020 онд холбогдох хуулийг баталж, 32 дугаар тогтоолоор “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх” арга хэмжээг баталсан. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний албан хаагчдыг түрээслээд өмчлөх хэлбэртэй орон сууцаар хангах зарим арга хэмжээ”-ний тухай 185 дугаар тогтоолыг баталсан. Үүний дагуу “**Нийслэлийн Орон Сууцны Корпораци**” хаалттай ХК-аас 5 ТЗК үүсгэн байгуулж, хаалттай хүрээнд нийт 1,929 түрээслээд өмчлөх орон сууцны зээлийг багцлан 149.9 тэрбум төгрөгийн орон сууцны түрээсээр баталгаажсан үнэт цаас гаргасан. Үүнээс тайлант хугацаанд 752 түрээсийн орон сууцны өмчлөх эрхийг багцлан 50.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий орон сууцны түрээсээр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргасан байна.

Хүснэгт 6. Төрийн бодлогын хүрээнд гарсан ХБҮЦ /“НОСК ТАВ ТЗК” ХХК /

| Тайлант хугацаанд | Зээлийн багц | Бүртгүүлсэн дүн |
|--------------------|--------------|-----------------|
| “Носк тав ТЗК” ХХК | 752 зээлдэгч | 50.0 тэрбум |


2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ

Тайлант хугацаанд **7,163** данс нээгдэж өссөн дүнгээр нийт **2,446,290** данс нээгдсэн байна. Мөн тайлант хугацаанд **31,541** холболтын данс нээгдэж нийт **567,901** холболтын данс нээгджээ.

2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц

Тайлант хугацаанд нийт арилжаанд дотоодын иргэний хийсэн арилжаа 49.55 хувь, дотоодын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 46.84 хувь, гадаадын иргэний хийсэн арилжаа 1.98 хувь, гадаадын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 1.63 хувийг тус тус эзэлж байна.

График 10. Гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны үнийн дүнд эзлэх хувь



Эх сурвалж: "Монголын үнэт цаасны клирингийн төв" ХХК

2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Биржийн бус зах зээлийн зохицуулалтыг орчныг тодорхой болгохоор “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Биржийн бус зах зээл нь биржийн зах зээлтэй харьцуулахад мэргэжлийн хөрөнгө оруулагчид оролцдог онцлогтой бөгөөд энэ нь

үнэт цаас гаргах гэж буй компаниудад тавигдах шалгуур нь харьцангуй бага байх, үнэт цаас гаргах цаг хугацаа, зардал хэмнэх зэрэг олон давуу талыг олгож байна.

Мөн Инновацийн тухай хуулийн 12¹ дэх заалтын дагуу “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-д холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулан баталсан бөгөөд цаашид гарааны компани хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгон гаргах боломжтой болсон.

Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс 2022 оны жилийн эцэс хүртэлх хугацаанд биржийн бус зах зээлд нийт 61 үнэт цаас гаргагчийн нийт 1.42 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 78 компанийн бонд гарсан бөгөөд 946.5 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн байна. Үүнээс тайлант хугацаанд 45 үнэт цаас гаргагчийн 739.6 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий, 169 транчтай 52 өрийн хэрэгслийг бүртгэж, 498.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн ба 227.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл гарахаар хүлээгдэж байна.

График 11. Тайлант хугацаанд ББЗЗ-д бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар ангилсан тоон мэдээлэл /хувиар/



Тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийн татан төвлөрүүлэхээр зарласан дүнг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар нь ангилбал банк бус 11%, хөрөнгө оруулалт 31%, үл хөдлөх 8%, уул уурхай 10%, санхүү 5%, бусад салбар 35%-ийг бүрдүүлж байгаа болт нийт өрийн хэрэгслийн татан төвлөрүүлсэн дүнг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар нь ангилбал банк бус 16%, хөрөнгө оруулалт 18%, үл хөдлөх 8%, уул уурхай 9%, санхүү 4%, бусад салбар 45%-ийг тус тус бүрдүүлж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

Өнөөдрийн байдлаар үнэт цаасны зах зээл дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, Инновацийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр хууль болон бусад холбогдох дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлж байна.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй 277 зохицуулалттай этгээд байна.

Хүснэгт 7. Үнэт цаасны зах зээлд оролцогчид

| № | Үйл ажиллагааны төрөл | Тоо |
|--|---|-----------------|
| Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа | | |
| 1 | Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага | 3 |
| 2 | Үнэт цаасны тооцооны байгууллага | 2 ¹ |
| 3 | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага | 1 |
| 4 | Үнэт цаасны төлбөрийн байгууллага | 1 |
| 5 | Хөрөнгө оруулалтын менежментийн компани | 38 |
| 6 | Хамтын хөрөнгө оруулалтын сан /хаалттай, нээлттэй/ | 4 |
| 7 | Кастодиан банк | 3 |
| 8 | Үнэт цаасны компани | 52 |
| | Брокер | 51 |
| | Үүнээс: | |
| | Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэгч | 13 |
| | Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээний үйлчилгээ үзүүлэгч | 14 |
| | Дилер | 33 |
| | Андеррайтер | 22 ² |
| | Хөрөнгө оруулалтын зөвлөх | 19 |
| 9 | Хөрөнгө итгэмжлэн удирдах | 8 |
| 10 | Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч | 1 |
| 11 | Тусгай зөвшөөрөлтэй компани /ХБҮЦ гаргагч/ | 49 ³ |
| 12 | Хөдөө аж ахуйн бирж | 1 |
| 13 | Хөдөө аж ахуйн брокер | 10 |
| 14 | Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага | 1 |
| Бүртгэлтэй хөндлөнгийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд | | |
| 15 | ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэх | 66 ⁴ |
| | Аудитын үйлчилгээ үзүүлэх | 48 |
| | Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх | 24 |
| 16 | ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх | 37 |
| Нийт (ТЗ болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын тоо) | | 277 |

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 184 ХК байна. Мөн Хорооны 2015 оны 06-р сарын 10-ны өдрийн 273 дугаар тогтоолоор Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо-г, 2015 оны 10-р сарын 13-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийг өөрийгөө зохицуулах байгууллагаар тус тус бүртгэсэн.

¹ Тус тоонд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болох “Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК болон “МУЦКТ” ХХК орсон болно.

² Тус тоонд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 банк /“Голомт банк” ХК, “Тээвэр Хөгжлийн банк” ХХК/ орсон болно.

³ Тус тоонд “МИК ОССК” ХХК-32, “ҮЦСК” ХХК-4, “Носк тав ТЗК” ХХК-5, нээлттэй хүрээнд ХБҮЦ гаргасан 7 ТЗК, хаалттай хүрээнд гаргасан 1 ТЗК тус тус орсон.

⁴ ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэх үйлчилгээг зэрэг үзүүлдэг 6 компани байна.

Хүснэгт 8. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй ХК-ийн тоо болон зах зээлийн үнэлгээ

| | Бүртгэлтэй ХК-ийн тоо | Зах зээлийн үнэлгээ 2022 |
|-----------------------------------|-----------------------|--------------------------|
| “Монголын Хөрөнгийн Бирж” ХК | 183 | 6,888,250,664,996 ₮ |
| “Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК | 1 | 2,107,910,466 ₮ |
| “Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК | - | - |

Тайлант хугацаанд “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-д бүртгэлтэй 183 компани байгаа бөгөөд бүртгэлтэй компаниудын нийт зах зээлийн үнэлгээ 6.88 их наяд төгрөгт хүрсэн бол “Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК-д бүртгэлтэй 1 компани байгаа бөгөөд зах зээлийн үнэлгээ 2.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлд голчлон анхаарч дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

4.1. Үнэт цаасны салбарын зохицуулалтын шинэчлэл

Үнэт цаасны бүртгэлийн зохицуулалт:

Санхүүгийн зохицуулах хорооноос дотоодын аж ахуй нэгжүүд хөрөнгийн зах зээлээр дамжуулан урт хугацааны санхүүжилт татаж, нээлттэй хувьцаат компани болох идэвх, сонирхлыг нэмэгдүүлэхтэй холбогдуулан нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах ажиллагаа /IPO/-г хялбар шуурхай болгох ажлын хүрээнд 2021 оны 225 дугаар тогтоолоор “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын шинэчилсэн найруулгыг олон улсын жишиг, зах зээлийн нөхцөл байдал болон өөрийн орны онцлогтой нийцүүлэн баталсан.

Энэхүү журам батлагдсанаар нийтэд санал болгон хувьцаа гаргах ажиллагааг хялбаршуулж, зардал, өртөг, цаг хугацааг хэмнэх боломжийг бий болгосон. Ингэснээр банкны системд нөлөө бүхий банкнуудын хувьд банкны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, IPO хийх ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх боломжтой болсон бөгөөд нээлттэй хувьцаат компани болсноор хувь эзэмшигчдийн төвлөрөл буурч, нэг хувьцаа эзэмшигчээс хамааралтай эрсдэлийн түвшин багасаж, олон нийтийн өмчлөлтэй болохоос гадна компанийн засаглал, мэдээллийн ил тод байдал сайжран үйл ажиллагааны ашиг, орлого өсөх давуу тал бүрдсэн.

Сүүлийн жилүүдэд дотоодын аж ахуйн нэгж байгууллагууд IPO болон хаалттай хүрээнд нэмж үнэт цаас (FPO) гаргах замаар хөрөнгийн зах зээл дээрээс хөрөнгө татах хандлага ихээр нэмэгдэх болсон нь иргэд, хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээл дэх оролцоо, түүний талаар мэдлэг, ойлголт сайжирснаас гадна бизнес эрхлэгчдэд дээрх санхүүгийн хэрэгслээр дамжуулан хөрөнгө татах эрэлт, хэрэгцээ өндөр байгааг харуулж байна.

Түүнчлэн Хорооны *2022 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 378 дугаар тогтоолоор Үнэт цаасны бүртгэлийн журмын нэмэлт, өөрчлөлтийг баталсан*. Дээрх журмын нэмэлт, өөрчлөлт батлагдсанаар арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах зохицуулалтын орчин тодорхой

болсноос гадна үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлж буй хууль, аудитын компаниудад тавигддаг шаардлагыг олон улсын жишигт нийцүүлэн хөнгөвчилсэн.

Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт:

Банкны системд нөлөө бүхий банкнудаас “Төрийн банк” ХК нээлттэй хувьцаат компани болох ажлыг түүчээлэн эхлүүлж, анхдагч зах зээлд хувьцаагаа санал болгосон эхний өдрөө л арилжааны захиалга нь 100 хувийг давж, хөрөнгө оруулагчдаас санхүүжилтээ амжилттай татан төвлөрүүлсэн бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчдын дунд санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, ялангуяа системийн банкнуудын хувьцаанд хөрөнгө оруулах эрэлт хэрэгцээ өндөр байгааг харуулж байна.

Энэ хүрээнд тухайн эдийн засгийн нэг салбарыг дагнасан мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хамтын хөрөнгө оруулалтын сангуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, банкны салбарын реформын хүрээнд системийн банкнудаар хөрөнгө оруулалт хийх бололцоог өсгөх хэрэгцээ, шаардлагын улмаас Хорооны 275 дугаар тогтоолоор баталсан *“Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”*-д нэмэлт, өөрчлөлтийг тусган, Хорооны 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 521 дүгээр тогтоолоор баталсан.

Төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцааг эзэмшихтэй холбоотой зохицуулалт:

Улсын Их Хурлаас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2022.04.29-ний өдөр баталсан ба тус хуулийн 56 дугаар зүйлийн 5-д “Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт энэ хуульд заасны дагуу нээлттэй хувьцаат компани болсон төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-т заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно”, 56 дугаар зүйлийн 6-д “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.5-д заасан улс төрд нөлөө бүхий этгээд, түүний хамаарал бүхий этгээд биржээр арилжаалах төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг эзэмшихийг хориглоно”, 56 дугаар зүйлийн 7-д “Энэ хуулийн 56 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавихтай холбогдсон журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална” гэсэн заалтуудыг тус тус нэмсэн.

Үүний дагуу 56 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалтын орчныг бий болгох хүрээнд *“Төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцааг эзэмшихтэй холбоотой хуульд заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавих журам”*-ыг боловруулж, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу Хорооны цахим хуудсанд байрлуулан санал авсан. Мөн холбогдох төрийн байгууллагууд болон үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудаас санал авч, журмын төсөлд холбогдох өөрчлөлтийг оруулан, Хорооны 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 520 дугаар тогтоолоор баталсан.

4.2. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн хөгжил

Монгол Улсын хөрөнгийн зах зээл нь олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч Их Британийн FTSE Russell компаниас тогтоодог “Хөгжиж буй зах зээл” /Frontier market/ ангиллын “Ажиглалтын жагсаалт”-д 2012 онд багтсан хэдий ч 2017 оны 9 дүгээр сард FTSE Russell компанийн Засаглалын зөвлөлийн хурлаас ажиглалтын жагсаалтаас арилжаанд оролцохын тулд мөнгөн хөрөнгийг 100% урьдчилан байршуулдаг, “DVP” буюу “Төлбөрийн эсрэг нийлүүлэлт”-ийн зарчмыг төлбөр

тооцоонд нэвтрүүлээгүй, олон улсын кастодиан банкны үйл ажиллагаа хөрөнгийн зах зээлд нэвтрээгүй зэрэг шалтгааны улмаас манай улс уг жагсаалтаас хасагдсан байна.

Улмаар Санхүүгийн зохицуулах хороо, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд болон мэргэжлийн оролцогч байгууллагууд бэлтгэл ажлыг ханган системийн хэмжээнд үнэт цаасны дараа төлбөр тооцооны горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг 2020 оны 3 дугаар сард амжилттай шилжсэнээр манай улсын үнэт цаасны төлбөр тооцооны горим олон улсын жишигт нийцэж, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох идэвх нэмэгдэж, хөрөнгийн бирж дээр хийгдэж буй хувьцааны арилжааны хэмжээ өсөх суурь нөхцөл бүрдсэн. 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр FTSE Russell-с Монгол Улсыг Хөгжиж буй зах зээл (Frontier market) ангиллын “Ажиглалтын жагсаалт”-д буцаж орсон талаар албан ёсоор мэдэгдсэн бол 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр *FTSE Russell зүүнээс Хөгжиж буй зах зээл (Frontier Market) ангилалд албан ёсоор орсон* талаар мэдээлсэн.

FTSE Russell-с гаргадаг энэхүү ангилалд Монгол Улс орсноор манай улсын хөрөнгийн зах зээлийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч, мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг татах, зах зээлийн арилжааны идэвх, хөрвөх чадварыг нэмэгдүүлж, хөгжлийг хурдасгах нөхцөл бүрдэх чухал ач холбогдолтой юм.

4.3. Банкны салбарын реформ:

УИХ-аас Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2021 онд баталсан нь арилжааны банкнуудад зохистой засаглалыг бий болгох, олон нийтийн хяналттай, нээлттэй, ил тод банкны салбарыг бүрдүүлэхэд томоохон түлхэц болох төдийгүй зөвхөн банкны салбар бус нийт санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, нэн ялангуяа хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой шийдвэр болсон. Банкны системд нөлөө бүхий банкнууд компанийн хэлбэрийг өөрчлөн зохион байгуулж, нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах буюу IPO хийх замаар 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани болох, мөн нэг хувьцаа эзэмшигчийн хувьцааны төвлөрлийг 20 хувиас хэтрүүлэхгүй байх шаардлагыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн бөгөөд энэхүү арга хэмжээ нь Монгол Улсын банк, санхүүгийн салбарын хөгжилд томоохон эерэг өөрчлөлтийг авчрах реформ болж байгаагаараа онцлог үйл явдал юм.

Банкны реформыг хэрэгжүүлснээр банкны үйл ажиллагаа ил тод, нээлттэй болж, хяналтын тогтолцоо илүү боловсронгуй болох, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөж, чанартай, хөрвөх чадвар өндөр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо нэмэгдэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх, оролцоо сайжрах, банкнуудад урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэр бий болохоос гадна олон тулгуурт санхүүгийн тогтолцоог бий болгоход чухал алхам болох юм. Энэ ч утгаараа Санхүүгийн зохицуулах хорооноос банкнууд хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулагдаж, олон нийтэд хувьцаагаа санал болгох ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай чиглэл, зөвлөгөө, мэдээллийг өгч, амжилттай зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэхэд түлхүү анхаарч ажиллалаа. Үүний үр дүнд Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 505 дугаар тогтоолоор *“Төрийн банк” ХК*-ийн нийтэд санал болгон гаргаж буй хувьцааг бүртгэсэн бөгөөд ингэснээр банкны салбарын реформын хүрээнд банкны системд нөлөө бүхий банкнуудаас нээлттэй хувьцаат компани болсон анхны банк болоод байна.

Мөн системийн банкнуудаас IPO хийж байгаа хоёрдогч банк болох “Голомт банк” ХК Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах зөвшөөрлөө авсны үндсэн дээр олон нийтэд танилцуулах ажиллагааг эхлүүлж, анхдагч зах зээлийн арилжаагаа 2022.11.23-ны өдөр албан ёсоор нээсэн. Тус банкны анхдагч зах зээлийн арилжаа эхний өдрөө 110.7 хувийн биелэлттэй хаагдсан бөгөөд анхдагч зах зээлд санал

болгох хугацаанд нийт 174,841,778,685 төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирүүлсэн нь татан төвлөрүүлэх дүнгээс 69.2 хувиар давсан буюу хөрөнгийн биржийн түүхэнд хамгийн өндөр дүнтэй захиалга болсон.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022.12.09-ны өдрийн ээлжит хуралдаанаар “ХААН банк” ХХК-ийн олон нийтэд гаргаж буй хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэж, анхдагч зах зээлд арилжих зөвшөөрлийг олголоо. Ингэснээр банкны салбарын реформын хүрээнд олон нийтэд анх удаа хувьцаагаа санал болгож, нээлттэй хувьцаат компани болох ажиллагаагаа хэрэгжүүлж буй банкны системд нөлөө бүхий гурав дахь банк болж байгаа бөгөөд Улсын Их Хурлаас баталсан Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, банк, санхүүгийн салбарт хэрэгжиж буй томоохон шинэчлэл амжилттай хэрэгжиж байгаагийн илрэл болж байна.

4.4. Хөрөнгийн зах зээл дэх шинэ бүтээгдэхүүн, мэргэжлийн хөрөнгө оруулагчид

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын хөрөнгийн зах зээлд зөвхөн хувьцаа, бонд гэсэн 2 төрлийн бүтээгдэхүүн л арилжаалагддаг байсан бол Санхүүгийн зохицуулах хорооноос шинэ бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх тал дээр онцгой анхаарал хандуулж, бодлого, зохицуулалтаар дэмжсэний үр дүнд 2020-2022 оны байдлаар үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар арилжаалагддаг хамтын сан /ХОС/, анхны дижитал компанийн бонд /Monpay/, анхны арилжааны зориулалттай буюу хөтөлбөрийн бус хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /ХБҮЦ/, банкны реформын хүрээнд гарсан банкны IPO /Богд банк, Төрийн банк, Голомт банк/ зэрэг нийт **51 шинэ бүтээгдэхүүн** гарсан байгаа нь хөрөнгийн зах зээлд чанартай, хөрвөх чадвар өндөр бүтээгдэхүүнд хөрөнгө оруулах эрэлт, хэрэгцээ өндөр байгааг харуулж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос олон улсын санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг дотоодын зах зээлд нэмэгдүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаа, оролцоог дэмжсэн **“Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”, “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”**-уудыг 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдөр тус тус шинэчлэн баталсан. Эдгээр журмыг баталснаар хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулахад тавигдах нөхцөл, шаардлага илүү хялбар болсноос гадна хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, нэгж эрхийн танилцуулгыг олон нийтэд танилцуулах, сангийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааны зохион байгуулалт, сангийн үйл ажиллагаа, активт тавих шаардлага, мэдээллийн ил тод байдалтай холбоотой зохицуулалт сайжрах боломж бүрдсэн. Тухайлбал, “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-аар хамтын нээлттэй болон хаалттай хөрөнгө оруулалтын сангийн онцлогоос хамааруулж үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг шинэчлэн тодорхойлохын зэрэгцээ сангийн активт тавих шаардлага, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах, сангийн цэвэр активын үнэлгээг тооцох, хамтын нээлттэй сангийн хувьд нэгж эрхээ санд буцаан худалдах, сан нэгж эрх гаргах ажиллагааг тогтмол зохион байгуулах ажиллагааны зохицуулалтыг Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-аас гаргасан зөвлөмж, судалгаанд үндэслэн бий болгосон.

Түүнчлэн олон улсын санхүүгийн зах зээлд өргөн хүрээнд ашиглагддаг хамтын сангийн төрөл болох биржээр арилжаалагддаг сан /ETF/-ийн зохицуулалтыг бий болгож, сангийн нэгж эрхийг анхдагч, хоёрдогч зах зээлд санхүүгийн хэрэгслээр солилцох ажиллагааг зохион байгуулах, уг үйл ажиллагаанд оролцогч мэргэжлийн үнэт цаасны компани /authorised participants/-д тавих нөхцөл, шаардлагыг тусгасан. Харин “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар тусгай зөвшөөрөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, нөхцөл, ёс зүйн зарчим, мэдээллийн ил тод байдал, үүрэг, хариуцлагыг сайжруулахын зэрэгцээ дотооддоо сонирхлын зөрчил

үүсэхээс сэргийлсэн тогтолцоо, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх болон дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжтэй байх зэрэг зохицуулалтыг бүрдүүлсэн.

Журмуудын зохицуулалт хэрэгжиж эхэлснээр хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалтын сангууд нэмэгдэж, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурь бэхжихээс гадна шинэ бүтээгдэхүүний тоо өсөж улмаар үнэт цаасны арилжаа, хөрвөх чадвар, зах зээлийн үнэлгээ нэмэгдэх юм. Цаашилбал гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх оролцоо, зах зээлд итгэх итгэл өссөнөөр хөрөнгийн зах зээлийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой бодлогын арга хэмжээ болсон.

4.5. Төрийн өмчит компаниудын хувьчлал

Улсын Их Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийг баталсан. Үүнтэй холбогдуулан Засгийн газраас 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар 2022-2023 онд биржээр төрийн мэдлийн 34 хувийн хувьцааг нээлттэй худалдах, олон нийтийн хяналтад шилжүүлэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг баталсан. бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс дээрх жагсаалтад багтсан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “Үндэсний давхар даатгал” ХК, “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК, “Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨҮГ-т нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах ажиллагаа /IPO/-г амжилттай хэрэгжүүлэхэд арга зүйн зөвлөгөө өгөх зөвлөмжийг хүргүүлсэн.

Банкны салбарын реформ хэрэгжиж байгаатай зэрэгцэн нэр бүхий төрийн өмчит хувьцаат компаниудыг хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлах ажиллагааг амжилттай хэрэгжүүлснээр компанийн засаглал, мэдээллийн ил тод байдал сайжирч, олон улсын жишгийн дагуу мэргэжлийн хөрөнгө оруулагчид удирдлагын багийг хэрэгжүүлж үйл ажиллагааны ашиг орлогыг нэмэгдүүлэх, улмаар гадаадын хөрөнгө оруулагчдыг татах чухал ач холбогдолтой юм.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022.12.14-ны ээлжит бус хуралдаанаар “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн нэмж гаргаж буй үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхээр шийдвэрлэсэн. Нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах зөвшөөрлөө авсны үндсэн дээр олон нийтэд танилцуулах ажиллагааг эхлүүлж, анхдагч зах зээлийн арилжаагаа 2022.12.26-ны өдөр албан ёсоор нээсэн.

Олон улсын санхүүгийн зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага буюу хөрөнгийн бирж нь ихэвчлэн нээлттэй ХК хэлбэртэй байдаг бөгөөд энэ жишгийн дагуу өөрийгөө зохицуулах байгууллага болох “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь нийт гаргасан хувьцааныхаа 34 хувийг олон нийтэд санал болгож олон нийтийн өмчийн оролцоотой компани болж байгаа нь УИХ, Засгийн газраас хэрэгжүүлж буй төрийн өмчит компаниудын хувьчлал амжилттай хэрэгжиж байгаагийн сайн жишээ болж байна.

4.6. “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн үр дүн

Дотоодын зээлийн эх үүсвэрийн болон банкны үйл ажиллагааны зардлыг бууруулахын зэрэгцээ санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, түүний эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх үндсэн зорилтын хүрээнд 2022 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолын хавсралтаар “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг баталсан. Үүнээс хойших хугацаанд уг стратегийн хэрэгжилт өндөр гүйцэтгэлтэй байгаа нь үр дүнгээ өгсөн бодлогын баримт бичиг болсон.

Тодруулбал, энэхүү стратегийн 4 дэх хэсэгт тусгагдсан “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах” арга хэмжээний хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, үнэт цаас хадгалалтын үйлчилгээний шимтгэл, хураамжийг 50-100 хувь хүртэл үе шаттай бууруулж, олон жил дан ганц арилжаа эрхлэх байгууллагаар дамжин санхүүжилт татдаг байсан тогтолцоог халж, биржийн бус зах зээлийн зохицуулалтын орчныг бүрдүүлэхийн зэрэгцээ дотоодын аж ахуй нэгжээс IPO хийх, компанийн бонд гаргах ажиллагааг хялбар шуурхай болгон зохицуулалтын орчныг тодорхой болгосон.

4.7. Хамтын ажиллагаа

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 390 дүгээр тушаалаар тус Хорооноос хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, санхүүгийн зах зээлийн бодлогыг тодорхойлох, зохицуулах, хянахтай холбогдсон үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. **Бодлогын зөвлөл 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр** хуралдаж, дотоодын хөрөнгийн зах зээлийн татварын эрх зүйн орчинд гарч буй эерэг өөрчлөлт, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны шимтгэл, хураамжийн хэмжээ буурч байгаа нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдын бааз суурийг бэхжүүлэхээс гадна гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, цаашлаад хөрөнгийн зах зээлийн санхүүгийн салбарт эзлэх байр суурийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж дүгнэсэн.

Хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ болон УИХ-аас баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хүрээнд хөрөнгийн зах зээлийн татварын орчин, шимтгэл хураамж, зах зээлийн мэргэжлийн байгууллагууд, хөрөнгө оруулагчдад ногдох татварын таатай орчныг бүрдүүлэх, татварын уян хатан бодлогоор Монгол Улсын томоохон ААН-үүдийг урамшуулалтайгаар биржид нээлттэй хувьцаат компани болгон бүртгүүлэх боломжийг нээх зорилгоор **“Хөрөнгийн зах зээлд гарч буй бодлого, зохицуулалтын үр нөлөө болон татварын эрх зүйн орчин” сэдэвт хэлэлцүүлгийг 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан.**

4.8. Уул уурхайн бүтээгдэхүүний бирж

УИХ-аас Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсантай холбогдуулан нүүрсний цахим арилжааг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хүртэлх хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан хийхийг Засгийн газарт, цахим арилжаанд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хороонд даалгасан. Түүнчлэн “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2022 оны 466 дугаар тогтоолоор “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ыг баталсан билээ. Уг журмын хэрэгжилтэд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавихаар зохицуулсан. Нүүрсний цахим арилжаатай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооноос арилжаа зохион байгуулах этгээд болон нүүрс худалдагч талуудтай хамтран ажиллаж, холбогдох чиглэл, саналыг өгч ажиллалаа.

ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР

---o-0-o---